

Уран сайхны кино дахь экологийн шүүмж “Уул усны үр сад” киноны жишээн дээр

Довжирийн Оргил

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ tuntger1103@gmail.com

Хураангуй: Дэлхийн экологийн хямрал хурцдаж байгаа энэ үед 1960-аад оноос барууны академиудад орчин үеийн экологийн шүүмж бий болж, дараа нь бусад өөр өөр салбарын хүрээнд хөгжиж, экологийн кино нь аажмаар байгаль орчны ёс зүй, гоо зүй, нийгмийн хөдөлгөөн хоорондын уялдаа холбоог ойлгох онолын чухал сэдэв болон хувирсан. Экокритицизмийн онол, Скотт Мак Дональд (Scott MacDonald)-ын экологийн киноны онолд тулгуурлан “Уул усны үр сад” гэх монголын уран сайхны киног задлан шинжилгээ хийж, түүний экологийн гоо зүй, нөлөөллийг харуулахыг зорилоо. Тус кино нь экологийн ямар асуудлыг хөндсөн, түүний бүтэц, киноны хэл, дуу дүрсний харилцаа, дүрүүдийн зөрчил зэрэг олон талт элементүүд нь хүн ба байгаль хоорондын ёс зүйн харилцаа, монголчуудын уламжлалт сэтгэлгээ, аман хууль, цээрлэх ёс, байгаль дэлхийг дээдлэн шүтэх ёс суртахууны үнэлэмжийг хэрхэн илэрхийлсэн талаар судалж, үүгээр бусад уран бүтээлчид ба үзэгчдийн амь ахуйгаа хайрлах үзэл ухамсарт ямар нөлөө үзүүлэх талаар судлав.

Түлхүүр үгс: *экокритицизм, экологийн сэдэвт кино, экологийн философи, монголын уламжлалт байгаль хамгааллын соёл, антропоцентризм*

On the Ecocriticism of Films: A Case Study of Mongolian Film Descendants of the Mountain Water (Uul usnii ur sad)

Orgil Dovjir

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ tuntger1103@gmail.com

Abstract: Against the backdrop of the global ecological crisis, modern ecocriticism emerged in Western academia in the 1960s and subsequently permeated diverse disciplines. Consequently, ecocinema has evolved into a pivotal theoretical framework for examining the intersections of environmental ethics, aesthetics, and social movements. Drawing upon ecocritical theory, this study analyzes the Mongolian film Descendants of

the Mountain Water (Уул усны үр сад) to elucidate its ecological aesthetics and broader implications. The paper investigates the film's ecological themes, structural composition, cinematic language, audio-visual dynamics, and character conflicts. Furthermore, it explores how these multifaceted elements articulate the ethical relationship between humanity and nature, collective responsibility, and moral values, while evaluating their impact on how artists and audiences perceive the philosophy of life.

Keywords: *ecocriticism, ecocriticism, ecocinema, ecophilosophy, mongolian traditional environmental stewardship, anthropocentrism*

Оршил

Экокритицизмийн (Экологийн шүүмжлэл) гарал үүслийг судлахын өмнө экологийн ойлголт, нэр томъёог судлах шаардлагатай. Экологи гэсэн нэр томъёог анх 1866 онд Э.Геккель дэвшүүлжээ (Лэй 2013). Энэ нь грек үгнээс гаралтай бөгөөд “ойкос”- орчин зүй, орон байр, оршин буй газар; “логос”- сургаал, шинжлэх ухаан, судлал гэсэн утгатай ажээ. Үүнээс үндэслэн “экологи” гэдгийг “орчин зүйн тухай сургаал”, “орчин зүйн тухай шинжлэх ухаан”, “хүрээлэн буй орчны тухай сургаал”, “хүрээлэн буй орчны тухай шинжлэх ухаан” гэх зэргээр ойлгож иржээ. Орчин үед экологийг организм хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн харилцах тухай асуудлыг судалдаг шинжлэх ухаан гэж ойлгох явдал нэлээд түгээмэл дэлгэрсэн байна (Сэнгэдорж 2015). Үүнээс өөр тодорхойлолт ч бий. Тухайлбал, организмын амьдралын үйл ажиллагааны зүй тогтлыг төрөлх орчинтой нь, түүнд хүний нөлөөллөөр орсон өөрчлөлттэй холбоотойгоор судалдаг шинжлэх ухаан гэж үздэг. Үүнээс үндэслэн экологийг “аутэкологи” “синэкологи” гэж ангилдаг байна.

Эхнийх нь ямар нэг организмыг бүхэл тогтолцооны бүрэлдэхүүн хэсгээс салган авч, зөвхөн түүний тодорхой орчинтой нь холбоотойгоор судлах явдлыг илэрхийлдэг бол хоёр дахь нь тодорхой нэгдлийг бүрдүүлж буй бүлэг буюу хэсэг организмыг цогцолбор байдлаар судлах явдлыг илэрхийлсэн ойлголт юм. Эдгээрийн аль аль нь байж болох боловч хоёр дахь нь шинжлэх ухаанд илүү ач холбогдолтой гэж үзэж болох юм. Сүүлийн үед үүнээс өөр нарийн нийлмэл нэр томъёо ч тохиолдох болов. Энэ нь “Моноэкохоломи” гэсэн латин, грек үгнээс үүсэлтэй “байгаль нэгдмэл байх тухай шинжлэх ухаан” гэсэн ойлголт юм. Эрнст Геккель (Ernst Heinrich Philipp August Haeckel) анх дэвшүүлсэн бөгөөд тэрээр организм ба хүрээлэн буй орчны харилцан хамаарлыг судлах шинжлэх ухааны үндсийг тавьсан юм.

Экокритицизм (экологийн шүүмжлэл) гэх хэллэг 1970-аад онд бий болж, 1974 онд америкийн эрдэмтэн Жозеф Микер (Joseph W. Meeker) “Оршихуйн эмгэнэл: Уран зохиолын экологийн судалгаа” хэмээх монограф хэвлүүлж, “Уран зохиолын экологи” (literary ecology) гэсэн нэр томъёог дэвшүүлжээ. Тэрээр шүүмжлэл нь уран зохиолоор илчлэгдсэн “Хүн төрөлхтөн ба бусад амьд бодис хоорондын харилцааг” судлах ёстой бөгөөд “Уран зохиол хүн төрөлхтний үйл ажиллагаа байгаль орчинд нөлөөлөх нөлөөг яаж нөлөөлж байгааг анхааралтай, чин сэтгэлээсээ судлах” ёстой гэжээ. Зохиогч мөн эртний грекийн жүжиг, Данте, Шекспир болон орчин үеийн уран зохиолын зарим бүтээлийг экологийн үүднээс шүүмжлэхийг оролдсон.

Мөн тус онд америкийн өөр нэгэн эрдэмтэн Карл Кроебер барууны шүүмжлэлд ихээхэн нөлөө үзүүлдэг эрдэм шинжилгээний сэтгүүл болох Орчин үеийн хэлний нийгэмлэгийн сэтгүүл (Journal of the Modern Language Society)-д “экологи” (ecology), “экологийн” (ecological) гэсэн ойлголтуудыг утга зохиолын шүүмжлэлд нэвтрүүлсэн өгүүлэл нийтлүүлсэн байна (Кроебер 1974).

НҮБ-аас 1972 оны 6-р сарын 12-нд Стокгольм (Stockholm, Sverige) хотноо хүний хүрээлэн буй орчны бага хурлыг зарлан хуралдуулж, улс орнууд Хүний хүрээлэн буй орчны тунхаглалд гарын үсэг зурснаар хүн төрөлхтөн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэлхий дахинд ухамсартайгаар эхлүүлсэн анхны тохиолдол болсон юм. Байгаль орчныг хамгаалах хүчин чармайлтыг эхлүүлснээр эко-уран зохиолыг түүхийн шатанд авчирч, эцэст нь барууны орнуудад үүсэж, хэлбэржсэн.

Энэхүү өгүүллийн гол зорилго нь Скотт Мак Дональдын (Scott MacDonald) экологийн киноны онол болон монголын нүүдэлчдийн гүн ухааны үзэл баримтлалд тулгуурлан, монголын уран сайхны кинон дахь антропоцентрик бус (хүн төвт бус) үзлийг тодорхойлж, судалгааны хүрээнд байгаль дэлхийг хүний хэрэглээний хэрэгсэл төдийхнөөр хардаг уламжлалт сэтгэлгээнээс татгалзаж, хүн ба байгалийг экосистемийн хувьд ижил үнэ цэнтэй, харилцан хамаарал бүхий эрх тэгш оршихуйнууд гэх үзлийг гадаад, дотоодын онолын нэгдэлд тулгуурлан, дэлгэцийн бүтээлд уран сайхнаар хэрхэн илэрхийлснийг шинжлэн гаргахыг зорив.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн, арга зүй

Түүвэр судалгааны аргыг ашиглан судалгааны үндсэн эх хэрэглэгдэхүүнээр “Уул усны үр сад” монголын уран сайхны киног авч ашиглав. Судалгааны зорилгыг биелүүлэхийн тулд экологи судлалын арга зүйг судлаачдын бүтээлд тулгуурлан холбон ашиглав. Онолын хувьд Скотт Мак Дональдын судалгааны хүрээнд гоо зүйн хувьд ба агуулгын хувьд экологийн киног тайлбарласан онолын үндсэнд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг хэрэглэв.

Судалгааны үр дүн

Скотт Мак Дональдын экологийн кино гэдэг нь антропоцентрик бус буюу хүн төвт бус үзлийг баримталдаг хүмүүс, үзэгчдэд шинэ байгаль ертөнцийг харуулсан кино гэсэн үзэлтэй тус кино нь нийцэж, тус киноны хэлэх санаа, гол дүрүүдийн үг үйлдэл, найруулагчийн найруулга зэрэг нь гоо зүйн болон агуулгын хувьд экологийн киноны онолтой нийцэж, экологийн сэдэвтэй монгол уран сайхны кино мөн гэж дүгнэв.

Экокритицизмийн үүсэл хөгжил. Экокритицизм хэмээх ойлголтыг анх 1978 онд Америкийн эрдэмтэн Уильям Рукелманн (William Ruckelmann) дэвшүүлсэн гэж үздэг. Түүний “Утга зохиол ба экологи: Экологийн шүүмж туршилт” (Literature and Ecology: An Experiment in Ecocriticism) хэмээх өгүүлэл нь 1978 онд Айовагийн (Iowa) шүүмж сэтгүүлийн өвлийн дугаарт нийтлэгдсэн нь “уран зохиол, экологи”-ийг “экокритицизм”-тэй хослуулсан байдаг.

Утга зохиол, соёлын шүүмжлэлийн чиг хандлага болох экологийн шүүмж нь 1990-ээд оны дунд үед АНУ-д бий болж, улмаар дэлхийн олон оронд бий болсон. “Экокритицизм” гэсэн нэр томъёоны олон тодорхойлолтуудын дундаас ихэнх судлаачдын хамгийн их хүлээн зөвшөөрсөн нэг нь Америкийн экологийн

шүүмжлэлийн гол төлөөлөгч, санаачлагч Шерил Глотфелти (Cheryll Glotfelty)-ийн “Экокритицизм бол уран зохиол ба байгаль орчны хоорондын хамаарлыг судалдаг шүүмжлэл юм” гэсэн тодорхойлолт юм. Тэрээр экологийн шүүмжлэл нь утга зохиол ба байгаль орчны хоорондын харилцааг судлахын тулд дэлхий дээр төвлөрөх санааг утга зохиол судлалд ашигладаг шүүмжлэл гэдгийг онцлон тэмдэглэв.

1992 онд АНУ-ын Невадагийн их сургуульд (The University of Nevada) “Утга зохиол, байгаль орчны судалгааны нийгэмлэг” байгуулагджээ. Утга зохиолын шүүмжлэлийн онолын хувьд экологийн шүүмжлэл анх 1970-аад оны эхээр үүсэж, 1990-ээд онд АНУ-д хөгжиж, улмаар дэлхий дахинд хурдацтай тархсан. Экологийн шүүмжлэл үүссэн нь XX зуунд янз бүрийн утга зохиол урлагийн шүүмжлэлийн объектод байгалиас байхгүй байсан нөхцөл байдлыг өөрчилж, байгалийн орчныг шүүмжлэлийн шинэ ангилал болгон авчээ. Экокритисизм нь хүн төрөлхтнийг “өөрийгөө ухамсарлах” (self-consciousness) байдлаас “экологийн ухамсар” (eco-consciousness) руу шилжүүлэхийг дэмжиж, хүн төрөлхтөн байгалийн эзэн байхаа больсон, харин байгалийн бусад амьд биеттэй ижилхэн амьдрал, үхлийг нэгэн адил эдлэх болсон гэж үздэг (Bate 2000).

Ливерпүүлийн их сургуулийн экологийн шүүмжлэгч Жонатан Бэйт (Jonathan Bate) “Байгаль болон байгаль дээрх бүх зүйл хэдийгээр ярих чадваргүй ч хуулиар хамгаалагдах ёстой. Мод, далайн гахай, халим, өвс, нэн ховордсон амьтад гэх мэтийг хамгаалах хуульчтай байх ёстой. Экокритикчүүд тэдний өмнөөс босож, үгээ хэлэхээс зайлсхийхийн аргагүй хариуцлагатай” (Bate 2000) гэж уриалав. Ийм учраас дэлхийн олон улс орон байгаль ба хүн төрөлхтнөөс бусад ургамал амьтдыг хууль эрх зүйн хамгаалалтад хамруулсан нь хүний ёс зүй, засаглалын чухал өөрчлөлт буюу хүний эрх ашигт анхаарлаа хандуулахаас эхлээд илүү өргөн хүрээтэй харилцаа руу шилжиж байгааг харуулж байна.

“Экокритицизм нь сэтгэц шинжлэхийн (Психоаналитик), эсвэл домог зүйн архетипийн шүүмжлэлтэй адил, экологийг утга зохиол судлалтай шууд уусган нэгтгэсэн чиглэл мэт ойлгогдох нь бий. Гэвч бодит байдал дээр тийм биш юм. Хэдийгээр зарим экокритикүүд экологийн судалгааны үр дүн, байгаль орчны шинжлэх ухааны баримтуудаас эш татдаг ч энэхүү шүүмжлэлийн байгалийн шинжлэх ухааны тал нь тэр бүр ил тод байдаггүй. Учир нь экокритицизм нь байгалийн шинжлэх ухааны нарийвчилсан туршилт, үр дүн гэхээсээ илүүтэй экологийн суурь үзэл баримтлал, тодруулбал, экологийн философийн санаануудад тулгуурладаг. Экологийн философи бол экологийн шүүмжлэлийн онолын эхлэл, үндэс суурь юм”. Кробер (Alfred Louis Kroeber) энэ талаар тодорхой мэдэгдэл хийсэн. Тэрээр “Экологийн шүүмж нь экологи, биохими, математик болон бусад байгалийн шинжлэх ухааны судалгааны аргуудыг уран зохиолын шинжилгээнд ашигладаггүй. Энэ нь зүгээрл экологийн философийн хамгийн үндсэн ойлголтуудыг утга зохиолын шүүмжлэлд нэвтрүүлдэг” (Kroeber 1994) гэжээ.

“Экокритицизм” гэх нэр томъёоны олон тодорхойлолтуудын дундаас ихэнх судлаачдад илүү их хүлээн зөвшөөрөгдсөн нь Америкийн экологийн шүүмжлэлийн гол төлөөлөгч, санаачлагч Шерил Глотфелти (Cheryll Glotfelty)-ийн “Экологийн шүүмж бол уран зохиол ба байгаль орчны хоорондын хамаарлыг судалдаг

шүүмжлэл юм” гэсэн тодорхойлолт юм. Шерил Гротефелти, Харолд Фромм нарын хамтран найруулсан “Экокритицизм уншигч” ном 1996 онд хэвлэгдсэн нь утга зохиол судлалын салбарыг “ногоонжуулах”-д тусалсан (Glottfelty and Fromm 1996).

Экологийн сэдэвт киноны үүсэл хөгжил. “Луи Жан Люмьер, Огюст Луи Мари Николя Люмьер хэмээх франц ах дүү хоёр 1895 онд америкийн зохион бүтээгч Эдисоны кинескопыг улам боловсронгуй болгож, сайжруулаад Парис хотын Капуцин хэмээх цэцэрлэгт хүрээлэнд “Галт тэрэг ирсэн нь”, “Ажилчид үйлдвэрээс гарч байна” хэмээх богино хэмжээний кино үзвэрийг нийтэд толилуулснаар киноны түүх эхэлдэг. Киног урлаг болгоход америкийн найруулагч Дэвид Гриффит (1875-1948), оросын алдарт найруулагч Сергей Эйзештейн (1898-1948) зэрэг уран бүтээлч жинтэй хувь нэмэр оруулсан билээ” (Наранжаргал 2021).

1960-аад оноос хойш дэлхийн экологийн хямрал улам ширүүсэж, агаарын бохирдол, цаг агаарын эрс тэс уур амьсгал, усны нөөц, биологийн олон янз байдлын хямрал зэрэг асуудлууд улам ширүүссээр байгаа нь хүн төрөлхтнийг өөрийн нөхцөл байдал, ирээдүйн хувь заяаны талаар гүн эргэцүүлэн бодоход түлхэц болсон юм. Утга зохиол, кино, телевиз болон бусад салбарт экологийн шүүмжлэл хурдацтай хөгжиж, хүн төрөлхтөн ба байгаль хоёр эсрэг тэсрэг, салангид оршихуй биш, харин харилцан уялдаатай, харилцан хамааралтай амьдралын тогтолцоо гэдгийг онцлон тэмдэглэсэн; ёс зүйн хариуцлагыг байгаль болон бусад амьтдыг хайрлан хамгаалах, хүндэтгэх гэж дахин тодорхойлох ёстой.

1975 онд нээлтээ хийсэн Холливудын “JAWS” кино нь Холливудын түүхэн дэх анхны экологийн сэдэвт кино төдийгүй уран сайхны киноны хамгийн анхны экологийн сэдэвт кино юм. Гэсэн хэдий ч тухайн үед хүмүүс энэ киног “экологи”-той холбон тайлбарлахаас илүүтэйгээр “триллер” аймшгийн сэдэвтэй л холбодог байв.

“Экологийн сэдэвт кино” гэж чухам юу болох талаар янз бүрийн орны эрдэмтэд өөр өөр үзэл бодолтой байдаг. Жишээлбэл, шүүмжлэгч Паула Виллокуте-Мариканди (Paula Willoquet-Maricondi) “Бие даасан уянгын болон баримтат киног л экологийн кино гэж үзэж болно. Учир нь тэдгээр нь эдийн засгийн эрс тэс хэлэлцүүлэг, үзэгчдийн үйлдлийг өдөөх магадлал өндөр байдаг” (Willoquet-Maricondi 2010).

Гэсэн хэдий ч ихэнх судлаачид баримтат, арилжааны гэх мэт үндсэн, алдартай, элит гэх мэт бүх кинонд соёлын утга агуулга агуулагддаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ нь хүн төрөлхтний нийгэм ба хүн бус ертөнцийн чухал байдлыг илэрхийлдэг. Сийн Күбетийн (Sean Cubitt) хэлснээр “Хэдийгээр олон кино өнөөгийн давамгайлж буй үзэл суртлын тухай, тэр дундаа байгалийн тухай үзэл санааны байдаг гэж дүгнэж болох ч, ихэнх киног экополитик гэж андуурч үздэг киноноос илүү зөрчилтэй, ёс зүй, сэтгэл хөдлөл, оюун ухааны хувьд илүү сэтгэл ханамжтай байдаг (Дональд Ворстер 1999). Экологи өргөн дэлгэр цар хүрээг багтаадаг учир олон сэдвийг анх харахад экологитой холбоогүй юм шиг санагддаг ч гүнзгийрүүлэн судалбал шууд болон шууд бусаар хүрээлэн буй орчинд нөлөөлж байдаг.

Америкийн эрдэмтэн Скотт Мак Дональдын 2004 онд бичсэн “Экологийн киноны зүг” өгүүлэл нь онцлох бүтээл байв. Энэ нь уг нэр томъёог кино шүүмжлэлийн хүрээнд албан ёсоор оруулсныг тэмдэглэв. Судалгааны хүрээнд

экологийн кино гэдэг нь гоо зүйн хувьд урт зураг авалт (long take), эвлүүлгийн хурдыг удаашруулсан (low editing)-ыг чухалчилж, агуулгын хувьд хэрэглээний үзлийг (consumerism) шүүмжилсэн, экологийн ухамсартай, хүн төрөлхтөн болон хүрээлэн буй орчны хоорондын хамаарлыг судалсан, үүнд амьдрах орчин, байгаль, амьтад зэрэг багтаах, дэлхий ертөнцийг антропоцентрикт бус (хүн төвт бус) үзлийг баримталдаг хүмүүс, үзэгчдэд байгалийн шинэ ертөнцийг харуулах гол зорилго бүхий кино гэжээ (Scott MacDonald 2004).


Америкийн гамшгийн тухай кино “Нөгөөдөр” (The Day After Tomorrow), “2012”, “Тусгаар тогтнолын өдөр” (Independence Day) нь гамшгийг үнэн бодитой юм шиг дүрсэлж, үзэгчийг үнэмшүүлсэн кино төрөл болохын хувьд аажмаар экологийн ёс зүйг илэрхийлэх, хүн ба байгаль орчны харилцааг судлах чухал хэрэгсэл болж байна. Гамшгийн тухай кинонууд нь үзэгдэх байдал, дуу хөгжим зэрэг гайхалтай туршлагаараа өндөр түвшинд үзэгчдийг татахаас гадна экологийн эмзэг байдал, технологийн засаглал, олон нийтийн ёс суртахууны талаарх хэлэлцүүлэг, эргэцүүлэхэд хүргэсэн.



Зураг 1. “Jaws”
киноны постр,
1978он



Зураг 2. “The day after tomorrow” киноны постр, 2004он



Зураг 3. “Avatar” киноны постр, 2009он



Зураг 4. “2012” киноны постр, 2012он

Барууны уламжлалт кино, телевизийн шоунуудад Христийн шашин бараг үргэлж цорын ганц итгэл үнэмшлийн систем байсаар ирсэн. Христийн шашны сургаалд хүн төрөлхтөн бол дэлхий дээрх Бурханы төлөөлөгч, Бурханы дүр төрхийн илрэл бөгөөд дэлхийн бүх хэргийг удирдах эрхтэй. Цаашилбал, хүн төрөлхтөн байгальд ямар ч хохирол авчирсан, хайраар дүүрэн Бурханы өмнө наманчлах юм бол нигүүлсэнгүй эзнээс өршөөлийг хүлээн авах болно. Иймээс Христийн шашны итгэл үнэмшлийн тогтолцоонд хүн төрөлхтөн бүхнийг чадагч, бүх зүйлийг захирдаг захирагч бөгөөд энэхүү ноёрхол нь юуны түрүүнд шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт ололтыг хөгжүүлж, судлах замаар илэрдэг. Гэсэн хэдий ч “Аватар” (Avatar) кино нь барууны экологийн энэхүү уламжлалт итгэл үнэмшлийн хязгаарлалтыг анх удаа даван туулсан юм. Экологийн сэдэвтэй “Аватар” кинонд барууны соёл иргэншлийн хязгаардмал байдлыг даван туулж, байгаль ертөнц, тэнгэр, хүн төрөлхтний эв нэгдлийн тухай дорно дахины ид шидийн экологийн итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрч эхэлсэн нь Пандора шиг ид шидтэй гарагийг бидэнд бэлэглэсэн юм. Энэхүү ид шидийн гариг

дээр сүнснүүдийн мод бол бүх амьд бодгалыг тээвэрлэгч бөгөөд бүх зүйл сүнсний модоор чөлөөтэй харилцах боломжтой. Нави хүний итгэл үнэмшил нь бүх зүйл тэгш байдаг бөгөөд энэ нь Пандора дээрх экологийн тэнцвэрт байдал, эв найртай хүмүүс хоорондын харилцааг хадгалах үндэс суурь юм. Хүн төрөлхтөн болон бүх төрөл зүйл нь ах эгч дүүс бөгөөд тэд онгон Мариагийн өмнө адил тэгш эрхтэй. Онгон Мария тэдний хэнийг нь ч дэмжихгүй, учир нь түүний үүрэг бол зөвхөн Пандорагийн экосистемийн тэнцвэрийг хадгалах явдал юм (Ан Шяофан, Гүө ШүЛи 2010).

Монголын экологийн сэдэвт кино. Монголд экологийн сэдэвт кино байдаг уу. Энэ бүс нутаг нь тал, хангай, ой мод, цөл, толгод зэрэг баялаг байгалийн тогтоцтой орчинд янз бүрийн амьдралын хэв маягаар зэрэгцэн оршдог олон угсаатны оршин суугаа бүс нутаг юм. Өвөг дээдсийнхээ экологи, байгаль орчноо хайрлаж хамгаалах зан үйлийг хатуу баримталж байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, үнэт зүйлсийг эрхэмлэдэг. Гэвч хувийн ашиг хонжоо, шунахай сэдэл, эдийн засгийн хэрэгцээндээ хөтлөгдөн байгаль дэлхийдээ хор хөнөөлтэй үйлдэл хийж хоёр нүүр гаргах, экологийн ухамсар доройтох, эсвэл амин хувиа хичээдэг хүмүүс байна. Иймд монгол экологийн кино, амь ахуйгаа хамгаалахын тухай кинонууд нь бүс нутгийн соёл, боловсролд зориулсан зохиол бүтээл төдийгүй байгаль орчны зөрчил, ёс зүйн сорилтуудыг илэрхийлж үзэгчдийг тогтвортой хөгжлийн талаарх олон талыг эргэцүүлэн бодоход түлхэц болдог.

Хэдийгээр монголын кино судлалын салбарт олон улсын “экокритицизм” хэмээх нэр томъёог онол, арга зүйн түвшинд тогтвортой ашигласан судалгаа өнөөг хүртэл өргөн дэлгэр хөгжөөгүй байгаа ч байгаль, хүн, орчны харилцааг бүхэллэг байдлаар авч үзэх үзэл санаа нь монголчуудын уламжлалт сэтгэлгээ, гүн ухаан, соёлын өвд эртнээс гүн шингэсэн байдаг. Тухайлбал, монголчуудын аман хууль, цээрлэх ёс, байгаль дэлхийг дээдлэн шүтэх зан үйл, нүүдэлчдийн ахуй соёл нь хүн байгальтай зохицон орших экологийн ухамсрыг төлөвшүүлж ирсэн чухал суурь болжээ.

Мөн “Их засаг” хууль зэрэг уламжлалт хууль цаазын дурсгалуудад ус, бэлчээр, ан амьтан, газар нутгийг хайрлан хамгаалах, байгалийн тэнцвэрийг алдагдуулах үйлдлийг цээрлэх тухай заалтууд тусгагдсан нь монголчуудын экологийн сэтгэлгээ зөвхөн ахуйн түвшинд бус нийгэм, төрийн зохион байгуулалтын хэмжээнд ч оршин байсныг харуулдаг. Иймээс өнөөдрийн экокритицизмын онолын үндсэн үзэл болох хүн ба байгалийн харилцан хамаарал, экологийн ёс зүй, хүрээлэн буй орчны хариуцлагын асуудал нь монголын уламжлалт соёл, сэтгэлгээнд тодорхой хэмжээгээр эртнээс бүрэлдэн тогтсон гэж үзэх үндэслэлтэй юм.

Доктор Н.Ганхуяг “Байгаль хэмээх үг нь “байх”, “байгаа”, “байгаагаараа” гэсэн л үг” (Ганхуяг 2020, 116) гэж хэлсэн нь байгалийг хүндэлж байгаагаар нь байлгах гэсэн санаа нь экологийн онолтой их ойртож байгаа билээ.

1988 онд хийгдсэн “Уул усны үр сад” кинонд Дунгармаа, Цэрэн хоёр буурай эмээтэйгээ түүний амь ахуйгаа хайрлан хамгаалах сургаалын дагуу хамт монголын тал нутагт амьдарч буй тухай өгүүлдэг. Харин тэдний хөрш Жунай нь байгаль орчныг сүйтгэгч бөгөөд түүний хүү Алтангэрэл ч муу зуршилтай хүүхэд байж. Алтангэрэл шувууны өндгийг хагална. Жунай ганц модыг хөрөөдөж унагаахын зэрэгцээ буурай ч өөд болж, Цэрэн өөр газар явж 20 жилийн дараа буцаж ирэхэд Дунгаамаа Алтангэрэлтэй гэрлэж, хоёр хүүтэй болсон ч Дунгаамаагийн биеийн

байдал тааруу, нөхөр нь түүнд хайр халамжгүй ханддаг. Эцэст нь Дунгаамаа нас барж, Рашаан булаг ширгэж, байгаль дэлхий ба гэр бүлийн хувь заяа ижилхэн сүйрч байгаа нь илхэн харагддаг.

Монголын нутагт өрнөж буй энэ кино нь хорин жилийн өмнө хойнох түүхийг өгүүлдэг. 20 жилийн өмнө экологид хандах хандлага, нийгмийн янз бүрийн байр суурь, ядуу баянаас болж ихээхэн зөрчилдөөн үүсэж байсан. Жунай болон түүний хүү Алтангэрэл экологийг сүйтгэсэн олон үйлдэл хийсэн. Буурай болон Дунгармаа, Цэрэн байгаль орчноо хайрлаж хамгаалах талаар маш сайн мэдрэмжтэй ч Жунай болон түүний хүүгийн үйлдлийг зогсоож чадаагүй тул тэднийг илт эсрэг тэсрэг хоёр тал болсон. Хорин жилийн дараа байгаль орчин муудсаар байна, рашаан ус ширгэж, мод сийрэгжиж, хүн байгаль хоёрын зөрчил гол асуудал болж хувирсан.

Дунгармаа, Цэрэн хоёр Жунай, Алтангэрэл хоёрт дургүй байгаагаа зохиосон үлгэрээр илэрхийлж, тэднийг чөтгөр, өөрсдийгөө баатруудын дүрээр дүрслэн, морь унаж ирсэн баатар тэднийг шийтгэдэг. Хоёр хүүхдийн өөрөө зохиосон үлгэр домог нь тэдний гэнэн цайлган зан, байгаль орчноо хайрлах ухамсрыг нь тод илэрхийлж чадсан. Буурай эмгэн хүүхдүүдтэйгээ гэртээ ярилцаж байхад:

Цэрэн: Тэгвэл хамгийн анхны ээж нь хаанаас гарах уу?
Буурай: Уул уснаас л гардаг юм. Ер нь газар эхээс л төрдөг юм. Явж явж бид цөм л уул усны үр сад шүү дээ гэж. Бас “Хүүхэд минь бид чинь цөм л газар усны үр сад, Гасна (Гурван гасна), хайрхны ач зээ, Сэлэнгэ мөрний дээс тунадас нь байгаа юм” гэж сургаж байсан нь ахмад нь залуу хойч үеэ сургаж буй тод дүр болж чадсан.

Нэр	“Уул усны үр сад”
Постр	
Кино гарсан он	1988 он
Уран бүтээлчид	Зохиолыг бичсэн: Д.Намсрай Ерөнхий найруулагч: Н.Нямдаваа Ерөнхий оператор: Д.Балчинпүрэв
Киноны төрөл	Уран сайхны кино

Үргэлжлэх хугацаа	68 минут
Үндсэн сэдэв	Хүн ба байгаль бол амь нэгтэй; амь ахуй экологийг хөнөөж байгаа нь өөрсдийгөө устгасантай адил юм.
Гол агуулга	Дунгармаа, Цэрэн хоёр буурай эмээтэйгээ түүний амь ахуйгаа хайрлан хамгаалах сургаалын дагуу хамт монголын тал нутагт амьдарч буй тухай өгүүлдэг. Харин тэдний хөрш Жунай нь байгаль орчныг сүйтгэгч бөгөөд түүний хүү Алтангэрэл ч муу зуршилтай хүүхэд. Тэрээр шувууны өндгийг хагална. Жунай ганц модыг хөрөөдөж унагаахын зэрэгцээ буурай ч өөд болж. Цэрэн өөр газар явж 20 жилийн дараа буцаж ирэхэд Дунгармаа Алтангэрэлтэй гэрлэж, хоёр хүүтэй болсон ч Дунгармаагийн биеийн байдал тааруу, нөхөр нь түүнд хайр халамжгүй ханддаг ба эцэст нь Дунгармаа нас барж, Рашаан булаг ширгэж, байгаль дэлхий ба гэр бүлийн хувь заяа ижилхэн сүйрч байгааг нь илхэн харагддаг.
Гол дүрүүд	Дунгармаа: Б.Уянга, Ш.Буянгэрэл Цэрэн: Т.Учираа, Б.Базаррагчаа Алтангэрэл: Ө.Эрдэнэчулуун, Д.Сосорбарам Буурай - Ч.Долгорсүрэн Жунай - Н.Дагийранз
Экологийн асуудал илэрсэн	Ойн хомсдол нь амьдрах орчныг сүйтгэж, экосистемийн үндсэн бүтцийг алдагдуулж, улмаар хөрс, усны хамгаалал, биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлдөг. Шувууны өндгийг устгаж байгаа нь жигүүртний нөхөн үржихүй, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байна. Бэлчээрийн нөөц ба усны нөөц (булаг)-ийн даац буурч байгаа нь байгаль орчны доройтол ба нөөцийн хэт ашиглалтын хоорондын уялдаа холбоог харуулж байна. Экологийн хямрал ба нийгэм, гэр бүлийн ёс суртахуун, соёлын өвийн хоорондох харгис мөчлөг, байгаль орчны сүйрэл нь олон нийтийн хувь заяанд хүчтэй нөлөө үзүүлж байгааг харуулж байна.
Илэрхийлж буй санаа	Дэлхий бол бүх амьдралын хамтын гэр бөгөөд түүний экосистем нь нарийн төвөгтэй, эмзэг бөгөөд хүний анхаарал халамж, хамгаалалтыг шаарддаг. Энэ нь биологийн олон янз байдлын ач холбогдол, хүн төрөлхтөн байгальтай харьцуулахад эмзэг байдал, хүн ба байгаль хоёр эв найртай зэрэгцэн орших зайлшгүй шаардлагатайг онцолжээ.

Кино эхлэхэд майханд сууж байгаа хоёр хүн хөөрөг солилцож,

А: Тарган тавтай сайхан зусаж байна уу? Рашаан ус зохимжтой биз?

Б: Сайхан зохиж байна, сайхан зун болж байна гэнэ. Түүний дараа рашаанд хөлөө хийж байгаа Цэрэнд Дунгармаа “Рашаанд бохир юм оруулж болохгүй, хүндэлж биширч байх ёстой гэж буурай хэлсэн” хэмээнэ. Шөнө нь буурай, Цэрэн, Дунгармаа гурав гэрт ийм яриа өрнүүлнэ.

Цэрэн: Рашаан чинь жирийн ус биш юм уу?

Буурай: Жирийн ус биш, хэргээ болохоор сүүнээс ч илүү.

Дунгармаа: Рашаан руу бохир юм оруулж болохгүй, тийм ээ.

Буурай: Болохгүй, яаж тэгж болох уу гэдэг ярианууд дүрүүдийн рашаан усаа хайрлаж байгааг тод илэрхийлсэн.

Кинонд гарч байгаа экологийн талаарх гол зөрчлүүдийг ангилбал:

ЗӨРЧИЛ				
Хүн төрөлхтөн ба байгаль	Хүн ба хүн (Дүрүүд)		Уламжлал ба шинэчлэл	
Мод	Буурай, Дунгармаа, Цэрэн,	Жунай, Алтангэрэл, Алтангэрэлийн 2 хүү	Нуур	Үйлдвэр
Ус				
Буга				
Шувуу				
Шувууны өндөг				
Тарвага				

Хэлэлцүүлэг

Нэлээд кино уран бүтээл үзэж, түүвэрлэж судалсны явцад тус кино уран бүтээлийг судалгаа, хэлэлцүүлгийн үнэ цэнтэй бүтээл гэж үзэж байна. Монгол уран сайхны кино төрөлд байгаль орчноо хамгаалах сэдэвтэй ба экологийн сэдэвтэй бусад кинонууд байдаг. Шерилийн үзэл баримтлал нь байгаль орчныг хамгаалах тухай ярихдаа хүн ба байгалийн хоорондын харилцаа нь субъект-объектын хоёрдмол байдал бөгөөд хүмүүс байгалиас тусгаарлагдсан байдаг; харин экологийн тухай ярихдаа хүн байгальд төрж, байгаль дунд байж бусад зүйлтэй субъект хоорондын харилцаатай байдаг, бусад биологитой тэгш эрхтэйгээр харьцаж, эв найртай зэрэгцэн оршдог болохыг харуулж байна гэжээ. “Уул усны үр сад” кинонд хүн ба байгаль тэгш эрхтэй бөгөөд эв найртайгаар зэрэгцэн орших ёстой гэсэн санааг тусгасан.

Тод дүрслэгдсэн дүрүүд нь амьдралын бодит жишээ бөгөөд зохиолд бичигдсэн янз бүрийн зөрчилдөөн нь зөвхөн монголын тал нутагт амьдарч байгаа ард түмэнд тулгарч буй асуудал төдийгүй дэлхий даяарх хүн төрөлхтний эргэцүүлэн бодох ёстой асуудлууд болно. Энэ нь зохиолч, найруулагчийн алсын хараа нь энгийн хүмүүсийнхээс давсан болохыг харуулж байна. Кино бүтээгдэж, дэлгэцэд гарснаас хойш бараг дөчин жил өнгөрсөн ч хэлэх санаа, илтгэх үзэл нь хуучраагүй. Эндээс улбаалан судлаачид эрдэм шинжилгээний хүрээнд хэлэлцүүлэх сэдэв хэвээр байж хойч үеийнхний судалж, үлгэр жишээ авах ёстой маш сайн бүтээл.

Дүгнэлт

“Уул усны үр сад” кинонд монгол нутгийн экологийн орчныг гол болгож хүн төрөлхтөн ба байгаль хоёрын харилцаанд анхаарч, амь ахуй ба хүн төрөлхтний хувь заяаны харилцан уялдаанд анхаарлаа хандуулж “Өөрийгөө ухамсарлах”(selfconsciousness) байдлаас “Экологийн ухамсар” (eco-consciousness) руу шилжиж байгалиа хүндэтгэх үзэл санааг хүчтэй илэрхийлжээ. Мөн монголчуудын уламжлалт соёл, “Их засаг” хууль зэрэгт байгаль хамгаалах ёс, экологийн хариуцлагын үзэл эртнээс оршиж ирснийг энэхүү бүтээл давхар сануулж байна.

Тус кинонд буурайгийн үг үйлдэл нь Жонатан Бэйтийн “Байгаль болон байгаль дээрх бүх зүйл хэдийгээр ярих чадваргүй ч хуулиар хамгаалагдах ёстой”

гэдэг онолтой нийцэж байгаа бөгөөд уламжлалт соёлыг хүндэтгэх, орчин үеийн шинэчлэлийн зөрчлийг хүртээмжтэй харуулжээ. Скотт Мак Дональдын экологийн кино гэдэг нь Антропоцентрик бус (хүн төвт бус) онолтой нийцэж, байгаль дэлхийг хүний хэрэглээний хэрэгсэл бус, бие даасан үнэ цэнтэй оршихуй болохыг үзэгчдэд ойлгуулсан байна.

Иймээс “Уул усны үр сад” кино нь зөвхөн экологийн сэдэвт кино болж чадсанаар зогсохгүй, монгол ахуй, зан заншил, байгальтай зохицон орших уламжлалт сэтгэлгээг уран сайхны өндөр түвшинд илэрхийлсэн бүтээл болжээ. Тус кино нь үзэгчдийн экологийн ухамсрыг дээшлүүлэхийн зэрэгцээ, цаашдын уран бүтээлчдэд үлгэр дуурайл болохуйц үнэ цэнтэй кино хэмээн дүгнэж байна.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Наранжаргал, Х. 2021. *Драмын зохиол туурвих ЗАМ-д гарья*. Улаанбаатар.

Сэнгэдорж, Т. 2015. *Экологийн эрх зүй газрын эрх зүй*. Улаанбаатар хот: Адмон.

Ганхуяг, Н. 2020. *Жүжиглэх ур чадвар*. Улаанбаатар: Мажеестск паблишинг компани.

Гадаад хэлээр:

Ан Шяофан, Гүө ШүЛи. 2010. ““Аватар” кинонд хийсэн экологийн задаргаа.” *Кино уран зохиол* 21(2): 113-114. 安晓芳, 郭淑丽. 2010. 对《阿凡达》的生态主义解读. *电影文学* 21 (2): 113-114.

Дональд, Ворстер. 1999. *Байгалийн эдийн засгийн тогтолцоо дахь экологийн сэтгэлгээний түүх*. Орч. Хоу Вэнхан. Бээжин: Арилжааны хэвлэл. 唐纳德沃斯特 (译. 侯文愍). 1999. *自然的经济体系生态思想史*. 北京: 商务印书馆出版.

Лин Шиян Лэй. 2013. “Экологи гэх нэр томъёог дурдсан нь.” *Шинжлэх ухаан, соёлын шүүмж* 10 (02): 18-28.

Bate, Jonathan. 2000. *The Song of the Earth*. London: Picador.

Cheryll Glotfelty and Harold Fromm. 1996. *The Ecocriticism Reader was published*. Вашингтон: University of Georgia Press.

Haeckel, Ernst. 1866. *Entwicklungsgeschichte der Organismen*. Berlin: Verlag von Georg Reimer.

Karl, Kreber. 1974. “Home at Grasmere: Ecological Holiness.” *Journal of the modern language society* 89 (No1): 132-141.

Karl, Kreber. 1994. *Ecological Literary Criticism: Romantic Imagining and the Biology of Mind*. New York: Columbia University Press.

Scott MacDonald. 2004. “Toward an Eco-Cinema.” *ISLE: Interdisciplinary Studies in Literature and Environment* (Oxford University Press): 107-132.

Willoquet-Maricondi, Paula. 2010. *Framing the world*. Charlottesville: University of Virginia Press.